



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 25

Алтай

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот
үйлдвэрийн газрыг татан буулгах
комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4, Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Барилгын зургийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан “Барилгын зураг төсвийн товчоо” ОНӨААТҮ-ийн газар, нийтийн зориулалттай орон сууцны захиалга авах, борлуулах, засвар үйлчилгээ хийх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан “Орон сууцны алба” ОНӨААТҮ-ийн газруудыг татан буулгах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Х.Баатарзориг /СТСХ-ийн дарга/

Нарийн бичгийн дарга: А.Баасандаш /Хууль зүйн хэлтсийн дарга/

Гишүүд: Л.Ганхуяг /Орон нутгийн өмчийн албаны дарга/

Д.Батсайхан /Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга/

Л.Энхжаргал /Нийгмийн даатгалын хэлтсийн дарга/

Ө.Наранбаатар /Татварын хэлтсийн дарга/

Н.Доной /Улсын бүртгэл, статистикийн хэлтсийн дарга/

Б.Мөнхжаргал /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга/

Д.Цолмон /Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ахлах
мэргэжилтэн/

П.Баасан /Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн/

Ц.Цээмаа /Орон нутгийн өмчийн албаны мэргэжилтэн/

Б.Бямбадорж /Барилгын зураг төсвийн товчоо ОНӨААТҮГ-ын дарга/

С.Эрдэнэ-Очир /Орон сууцны алба ОНӨААТҮГ-ын дарга/

2. Татан буугдаж буй хоёр байгууллагын дуусгалтын балансыг гаргуулан, өр авлагыг бүрэн барагдуулж дүнг 2016 оны 07 дугаар сарын 20-ны дотор танилцуулж ажиллахыг комиссын дарга /Х.Баатарзориг/-д даалгасугай.



ДАРГА

А.ДЭЛГЭРЖАРГАЛ